

УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ  
БАЙРЛАХ “ШАРГЫН ЭЗЭН” ХХК-ИЙН “НООС НООЛУУР ЭЭРЭХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН  
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

1.1.Төслийн нэр: “Ноос ноолуур ээрэх үйлдвэр” төсөл

1.2.Төсөл хэрэгжүүлэгч:

Хувийн хөрөнгө оруулалттай “Шаргын эзэн” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9011819223,  
Регистрийн дугаар: 6586775, Газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар 000321414

1.3.Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:


Улаанбаатар хот, Сүхбаатар 20-р хороо, сэлбэ 10-1019 тоот. Утас:99728656, Захирал  
П.Сандагсүрэн

1.4.Төслийн байршил:

Төсөл хэрэгжих талбай нь Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 20 - р хорооны нутаг  
дэвсгэрт нийт 2800 квадрат метр талбайд байрлаж байна.

Хүснэгт 1.Ээрэх үйлдвэрийн талбайн солбилцол

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	107	0	11.921	48	2	46.077
2	107	0	12.17	48	2	47.484
3	107	0	15.305	48	2	47.402
4	107	0	15.278	48	2	46.72
5	107	0	15.187	48	2	46.722
6	107	0	15.152	48	2	46.069



Зураг 1. Байршлын зураг



Зураг 2. Ээрэх үйлдвэрийн барилга

### 1.6. Төслийн хүчин чадал

Тус компанийн ээрэх үйлдвэр нь хонины ноосон утас үйлдвэрлэх зориулалттай ноос самнах 2 шугам, ээрэх 2 шугам, ороох 1 шугам, ноосны холионы 1 шугам суурилуулан үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхлүүлсэн ба жилд 130 тонн ээрмэл утас үйлдвэрлэх хүчин чадалтай ба 12/1 номерын дан эрчтэй утас үйлдвэрлэж байна.

Ноосны холионы машин нь ноосыг задлаж бусад холионы материалтай тусгай зориулалтын тос болон антистатиктай хольж эмульсжүүлэн ноосны холиог амраах өрөө буюу лабазуудруу агаарын хоолойгоор зөөвөрлөдөг машин юм.

Ноос самнах машин нь холионы машинаар дамжиж эмульсжсэн ноосон холиог янз бүрийн номерын туузан зүүн гадрагатай үндсэн, ажлын, хуулах үүрэгтэй эргэлдэх голуудаар дамжуулан ноосыг ширхэгийн дагуу тэгшилж сунган ээрэх процессын бэлдэц болох цувималыг гаргаж авдаг.

Ээрэх машин нь самнах шугамаас гаргаж авсан цувималыг татаж сунган эрч оруулж ээрмэл утас болгон 500 ширхэг нарийн голонд ороодог.

Шилжүүлэн ороох машин нь ээрэх шугамын гаргасан нарийн гол бүхий утаснуудыг нэг голонд шилжүүлэн ороох эцэсийн дамжлага юм.

Хүснэгт 2. Түүхий эдийн хэрэгцээ, татан авалт

№	Түүхий эдийн жагсаалт	Химийн нэршил	CAS дугаар	Химийн томьёо	Татан авалт	Сав баглаа боодол	Хүссэн хэмжээ Жил/ кг
1	Ээрэхийн шингэн тос	Spintek HFS	68439-46-3 61791-26-2	Нийлмэл	Хэрроу	Хуванцар савтай	2000
2	Цахилгаанжилтыг бууруулагч/Антистатик/	Disperstat IP	1474044-65-9 532-32-1 107-21-1	Нийлмэл	Хэрроу		1500

Хүснэгт 3. Үйлдвэрийн тоног төхөөрөмж

№	Шат дамжлага	Нэр	Марк	Хүчин чадал	Үйлдвэрлэсэн улс	Зураг

УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ  
 БАЙРЛАХ “ШАРГЫН ЭЗЭН” ХХК-ИЙН “НООС НООЛУУР ЭЭРЭХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН  
 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

1	Холионы цех	Ноос сэмлэх машин	BC 262	цагт 200кг ноос сэмлэх 5,5 kw, 1440 г/min-2 ширхэг 4 kw, 1440 г/min- 1 ширхэг 7.5 kw, 720 г/min- 1 ширхэг нийт 4 мотортой	-	
2	Самнах цех	Ноос самнах машин 1-р шугам	2053 01 178 020	цагт 20кг ноос самнах 7,5kw, 970 г/min-1 ширхэг 11kw, 970 г/min- 1 ширхэг нийт 2 мотортой	Полш	
3	Самнах цех	Ноос самнах машин 2-р шугам	2053 01 148 032	цагт 20кг ноос самнах 7,5kw, 970 г/min-1 ширхэг 1kw, 970 г/min- 1 ширхэг нийт 2 мотортой	Полш	
4	Ээрэх цех	утас ээрэх машин 1-р шугам	МАТ R 1499	цагт 20кг утас ээрэх 1kw, 1450 г/min-1 ширхэг 8kw, 2590 г/min- 1 ширхэг нийт 2 мотортой	Итали	

**УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ  
БАЙРЛАХ “ШАРГЫН ЭЗЭН” ХХК-ИЙН “НООС НООЛУУР ЭЭРЭХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН  
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

5	Ээрэх цех	утас ээрэх машин 2-р шугам	МАТ R 1686	цагт 20кг утас ээрэх 1kw, 1450 г/min-1 ширхэг 8kw, 2590 г/min- 1 ширхэг нийт 2 мотортой	Итали	
6	ороох цех	утас шилжүүлэн ороох машин	13957 55333 0	цагт 40кг утас ороох	Хятад	

**Ээрэх үйлдвэр**

Ноос ноолуурын үйлдвэрүүдийн чухал дамжлага нь ээрэх үйлдвэрлэл. Сүлжмэл болон нэхмэл бэлэн бүтээгдэхүүний чанар нь ээрмэл утасны чанараас шууд хамаардаг. Технологи нь самнах, ээрэх, шилжүүлэн ороох, давхарлан ороох, эрчлэх зэрэг таван үндсэн дамжлагатай байдаг.

**Холионы цех**

Ноосны эдэлгээний шинж чанарыг уртасгах зорилгоор 70x30 харьцаатайгаар цэвэр модноос гаргаж авсан вискоз хэмээх утсыг ноостой хольж 70%- ийн ноосны агууламжтай утас гаргахад бэлэн болно гэсэн үг. Учир нь ноосны өөрийнх нь онцлог шинж чанараас шалтгаалан бөмбөлөг үүсэх буюу бидний нэрлэж заншсанаар амархан бөөсрөх явдал их гардаг, амархан элэгдэж цоорох явдал гардаг тул вискозыг хольж өгснөөр дээрхи бэрхшээлүүд нилээн багасдаг сайн талтай. Гэхдээ бид зах зээлийн байдалд тохируулан тодорхой хэмжээгээр 100%-тай ноосны агууламжтай утас үйлдвэрлэхийг хичээдэг.

Мөн түүнчилэн ангилан ялгасан зарим утсаа натураль өнгөөр нь химийн ямар нэг хольц урвалд оруулахгүйгээр утас ээрэх тул энэхүү натураль өнгийн утас нь тодорхой хэмжээний өртөг бага гарах сайн талтай.



Зураг 3. Ноос холих машин



Зураг 4. Ноос сэмлэх машин



Зураг 5. Ноос самнах машины 1-р шугам болон 2-р шугам

Сэгсрэх, задлах, самнах ажиллагаа – ноос, ноолууранд агуулагдах ургамлын болон бусад төрлийн хогт хольцыг цэвэрлэх, ширхэгтүүдийг задлаж салгаад ээрмэлийн үйлдвэрлэлийн хагас боловсруулсан бүтээгдэхүүн (тууз, цувимал) үйлдвэрлэхэд бэлэн болгоно.

Бэлэн болсон цувималыг ээрч сунган нарийсгаж утас болгох ээрмэлийн үйлдвэрийн үндсэн дамжлага.



Зураг 6. Бэлэн болсон ээрсэн утас

### 1.7.Төслийн дэд бүтэц

“Шаргын эзэн” ХХК-ийн үйлдвэр нь Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт оршиж байгаа бөгөөд засмал замаар холбогдсон, 380Вт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамд холбогдсон, халуун болон хүйтэн усны сүлжээнд холбогдсон, дэд бүтэц сайтай газар байна.

**Цахилгаан эрчим хүч** - Нийслэл хотын төвийн шугам сүлжээнд холбосон. Ноос ноолуур ээрэх үйлдвэр нь цахилгаан эрчим хүчийг үйлдвэрийн гадна дотор гэрэлтүүлэг, агааржуулалт, холбооны ахуйн хэрэглээнд, цэвэр усыг зөвхөн ахуйн хэрэглээнд ашиглах юм.



Зураг 7. Цахилгаан хангамж

**Дулаан хангамж:** Нам даралтын уурын зуух ашигладаг.

УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ  
 БАЙРЛАХ “ШАРГЫН ЭЗЭН” ХХК-ИЙН “НООС НООЛУУР ЭЭРЭХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН  
 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 8. Уурын зуух



Зураг 9. Галаас урьдчилан сэргийлэх самбар болон аюулгүй ажиллагааны самбар

**Унд ахуйн хэрэглээний цэвэр ус** –Гүний худгаас унд ахуйн хэрэгцээгээ хангана.

*Цэвэр ус* – Ажилчдын унд ахуйн хэрэглээний цэвэр усыг өөрийн хашаан доторх гүний худгаас хангана. Төсөлд нийт 20 хүн ажиллана. Нэг хүний ус хэрэглээний норм хоногт ахуйн хэрэгцээнд 50 л ус хэрэглэнэ гэж тооцоход хоногт 1 м<sup>3</sup> жилд 295 м<sup>3</sup> ус ашиглахаар байна. (\*- *БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалын 12 дугаар хавсралт* –“Орон сууц, нийтийн байр, гэр хорооллын усны норм”, *Төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн системд холбогдоогүй орон сууц* – 50 л/хоног/хүн)

*Төсөлд бага оврын зуух хэрэглэдэг ба ус ашиглахгүй тосоол ашигладаг.*

Хүснэгт 4. Төслийн ажилчдын унд ахуйн усны тооцоо

Усны хэрэглээний төрөл	Төслийн хугацаа, хон/жил	Норм	Хүний тоо	Ус хэрэглээ	
				м <sup>3</sup> /хон	м <sup>3</sup> /жил
Унд-Ахуйн	295	50л/хон/хүн	20	1	295

**УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ  
БАЙРЛАХ “ШАРГЫН ЭЗЭН” ХХК-ИЙН “НООС НООЛУУР ЭЭРЭХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН  
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

(\*- БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралт –“Хөнгөн үйлдвэрийн салбарын усны норм”, Ээрмэлийн үйлдвэр тонн ээрмэл 146,5м<sup>3</sup>)

**Хүснэгт 5. Үйлдвэрүүдийн усны норм, тооцоо**

Үйлдвэрийн нэр	Хүчин чадал /өдөрт/	Норм /1тн/	Ус хэрэглээ	
			м <sup>3</sup> /хон	м <sup>3</sup> /жил
Ээрэх үйлдвэр	0.44тн	146,5	64.46	19015,7


Ээрэх үйлдвэрийн усны норм тооцоог хийв. Тус үйлдвэрд ашиглагдах нийт усны хэмжээ нь жилд 19015,7 м<sup>3</sup> хэмжээтэй байна.

**Хүснэгт 6. Гүний худгийн товч мэдээлэл**

№	Үйлдвэрийн нэр	Ундрага л/с	Гүн, м	Координат	
				Өргөрөг	Уртраг
1	Ээрэх үйлдвэр	0.8	71	48° 2'46.54"N	107° 0'12.69"E

“Шаргын эзэн” ХХК-ийн төслийн талбай дотор 1 гүний худаг байрлана. Уг гүний худгаас үйлдвэрүүд унд ахуйн болон үйлдвэрлэлд хэрэгцээтэй усыг авч ашигладаг.

- Ээрэх үйлдвэр нь 71 м гүнтэй, ус ашиглалтын усны ундарга 0,8л/с, худгаас хоногт 69,12 м<sup>3</sup> ус авч ашиглах боломжтой. Үйлдвэр нь хоногт дунджаар 65.46м<sup>3</sup> ус ашигладаг.



**Зураг 10. Худгийн байршил**

**Хог хаягдал**

Хатуу, шингэн хог хаягдал нь хүн ам, үйлдвэрлэлд хэрэгцээт газрын нөөцийг багасгах, хөрс, ус, агаарыг хорт бодис, хүнд металл, нян вирусээр бохирдуулагч гол эх үүсвэр болдог. Хатуу хог хаягдал нь удаан задарч бодисын эргэлтэд аажмаар орох ба задрах хугацаа нь удаан байдаг учраас байгаль орчинд хор хөнөөлтэй.

Төслийн үйл ажиллагааны явцад гарах хог хаягдал нь ахуйн болон технологийн үйл ажиллагаанаас үүснэ. Хэлбэрээр нь:

1. Хатуу
2. Шингэн
3. Хийн гэж ангилна.



### **Хатуу хог хаягдал**

Хатуу хог хаягдлын менежментийн үндсэн зарчим нь эх үүсвэрийг хязгаарлах, хаягдлыг тусгайлсан горимын дагуу байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй хэлбэрээр цуглуулах, хог хаягдлыг богино хугацаанд зайлуулан, орчныг цэвэрлэх зэрэг арга хэмжээнд тулгуурлана.

**Ахуйн гаралтай хатуу хог хаягдал:** Тус төслөөс гарах ахуйн гаралтай хатуу хог хаягдлын эх үүсвэр нь ажилчдын хэрэглээ, хоол бэлтгэлийн явц байх болно. Хатуу хог хаягдлын дийлэнх хувийг сав баглаа боодол эзэлнэ.

- Байгууламжийн үйл ажиллагаанаас доорх нэр төрлийн хатуу хог хаягдал гарна.
- Хүнсний зүйлсийн сав, баглаа боодол
- Бие засах газрын хаягдал
- Ундааны сав, лааз
- Хоолны үлдэгдэл

Тус төсөлд 1 хүнээс өдөрт дунджаар 0,3 кг хог хаягдал үүсдэг гэдгийг тооцвол үйлдвэрийн хувьд өдөрт 20 хүн ажиллаж, хоногт үүсэх ахуйн гаралтай хог хаягдлын хэмжээ нь кг, сард 180 кг гарах ба үүнийгээ тусгай зориулалтын тагтай саванд хадгалж байгаад СБДүүргийн ТҮК–тэй гэрээ байгуулан ачуулдаг.

**Технологийн хаягдал:** Төслийн технологийн үйл ажиллагаанаас хатуу хаягдал гарах бөгөөд зөвхөн ахуйн гаралтай хатуу хог хаягдал гарна. Бүтээгдэхүүний сав, баглаа, боодол зэргийг устгах, хадгалахдаа 2017 оны 5 сарын 12-ны өдрийн “Хог хаягдлын тухай” хуулийн, Аюултай хог хаягдал хадгалах, устгах тогтоомжийн дагуу ажиллах шаардлагатай.

### **Хог хаягдлыг зайлуулах арга хэмжээ**

**Энгийн хог хаягдал** - Төсөл хэрэгжүүлэгчид энгийн хог хаягдлыг дараах байдлаар зайлуулах, мөрдөж ажиллах зөвлөмжийг санал болгож байна.

1) “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам” -ын дагуу энгийн хог хаягдлаа ангилан ялгах шаардлагатай.

2) Дараах шаардлагыг хангасан хогийн савтай болох шаардлагатай. Үүнд:

- Хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн;
- Галд тэсвэртэй материалаар хийгдсэн;
- Хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн байх

3) Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах, эсвэл сум орон нутгаас зөвшөөрсөн хогийн цэгт хаях

4) Бусад :

- Хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх;
- Хог хаягдлын талаархи сургалтад хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлэх;
- Хамгийн боломжит арга технологи, байгаль орчинд ээлтэй арга ажиллагааг нэвтрүүлэх замаар хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах;
- Хог хаягдлын талаархи хууль тогтоомж, стандартын шаардлагыг хангаж ажиллах;
- Хог хаягдлын улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулсан, учруулж болзошгүй байдал бий болсон тохиолдолд тухайн шатны засаг дарга болон онцгой байдал, цагдаа, эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэх;
- Аж ахуйн нэгж, байгууллага нь байгууллагын ажилтнуудад хог хаягдлын менежментийн талаар сургалт зохион байгуулж, зохих мэдлэгийг эзэмшүүлэх, дадал зуршлыг хэвшүүлэх;

### **Аюултай хог хаягдлыг зайлуулах**

УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ  
БАЙРЛАХ “ШАРГЫН ЭЗЭН” ХХК-ИЙН “НООС НООЛУУР ЭЭРЭХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН  
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

- Аюултай хог хаягдал үүсгэгч болон аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь бүртгүүлж, бүртгэлийн дугаар авсан байна.
- Аюултай хог хаягдал үүсгэгч нь аюултай хог хаягдлыг дараахь хугацаанд эх үүсвэр дээр түр хадгалж болно.
- 1 сард 1000 килограммтай тэнцүү буюу түүнээс бага аюултай хог хаягдал үүсгэдэг бол 180 хоног;
- 2 сард 1000 килограммаас их хэмжээтэй аюултай хог хаягдал үүсгэдэг бол 90 хоног.
- Тодорхой шалтгааны улмаас заасан хугацаанаас илүү хугацаагаар хадгалах бол аймаг, нийслэлийн хог хаягдлын менежментийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж, түр хадгалах зөвшөөрөл авна.
- Аюултай хог хаягдлыг агааржуулалтын системтэй, тухайн хаягдлыг хадгалах нөхцөлийг хангасан орчинд хадгална.
- Аюултай хог хаягдлын үүссэн болон хуримтлагдсан хэмжээг нэр, төрөл бүрээр бүртгэх.
- Үүссэн аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгөх;
- Аюултай хог хаягдал үүсгэгч нь зөвшөөр бүхий байгууллагад шилжүүлэхэд маягтын дагуу дагалдах бичгийг бүрдүүлнэ.
- Аюултай хог хаягдал үүсгэгч нь аюултай хог хаягдал хариуцсан орон тооны болон орон тооны бус ажилтантай байна.
- Үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах эрх бүхий байгууллагад шилжүүлэх, эдгээр үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын дотоод болон гадна орчны цэвэрлэгээг хариуцах үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байх;

Иймд Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А-429/257 дугаар тушаалаар **“Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалт”** батлагдсаны дагуу үйл ажиллагаа эрхлэгч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, булшлах үйл ажиллагааг хариуцна. Үүнд:

1. Химийн хорт болон аюултай бодисын сав баглаа боодол;
2. Хуванцар сав суулга, түүхий эд;
3. Аюултай хог хаягдал орно.

БОАЖСайдын 2018 оны 01-р сарын 30 өдрийн А/18 тоот журамны 2, 3-р хавсралтын дагуу цуглуулах хадгалах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг авсан хаягдал сав баглаа боодол авдаг компаниудтай гэрээ байгуулан ажиллах хэрэгтэй. Төсөл хэрэгжүүлэгч нь ээрэхийн шингэн тос, цахилгаанжилтыг бууруулах гэсэн 2 төрлийн химийн бодисыг “Хэрроу” ХХК-с худалдан авч үйлдвэрлэлдээ ашигладаг. Сав баглаа боодлыг нь буцааж эргүүлэн өгдөг.

**Хог хаягдалтай холбоотой дараах үйл ажиллагааг хориглоно:**

- Хог хаягдлыг дэд бүтцийн шугам хоолойд хаях
- Нийтийн эдэлбэр газар, ногоон бүс, үерийн далан сувагт хог хаягдал хаях
- Хог хаягдлыг ил задгай шатаах
- Гэр буудалд нийлэг материалтай хог хаягдлыг шатаах
- Хог хаягдлыг хогийн сав болон тогтоосон цэгээс бусад газарт хаях
- Хөрс бохирдуулагч жорлон байгуулах

### Хог хаягдлыг зөөж тээвэрлэх

Төслийн үйл ажиллагаанаас гарах хатуу болон аюултай хог хаягдлыг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулж сард нэг удаа тээвэрлүүлдэг байна.

**Технологийн хаягдал:** Төслийн технологийн үйл ажиллагаанаас хатуу хаягдал гарахгүй бөгөөд зөвхөн ахуйн гаралтай хатуу хог хаягдал гарна. Химийн бодисын сав баглааны бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавин ажиллах нөхцөлд технологийн хатуу хаягдал гарахгүй болно. Бүтээгдэхүүний сав, баглаа, боодол зэргийг устгах, хадгалахдаа “Химийн хорт болон аюултай бодисын тухай” хуулийн 14.1-т заасны дагуу 2017 оны 5 сарын 12-ны өдрийн “Хог хаягдлын тухай” хуулийн, Аюултай хог хаягдал хадгалах, устгах тогтоомжийн дагуу ажиллах шаардлагатай.

**Шингэн хаягдал:** Технологийн үйл ажиллагаанаас шингэн хаягдал гарахгүй бөгөөд зөвхөн ахуйн гаралтай шингэн хаягдал бага хэмжээгээр гарна. Үйлдвэр нь ариун цэврийн өрөөнүүдтэй. Үйлдвэрээс гарах шингэн хог хаягдлыг соруулж Улаанбаатар хотын нэгдсэн цэвэрлэх байгууламжид нийлүүлдэг.



Зураг 11. Үйлдвэрийн ариун цэврийн өрөө



Зураг 12. Бохир соруулах машин



Зураг 13. Бохир соруулдаг худаг

### ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Дээр өгүүлсэн болзошгүй нөлөөллийн судалгааны үр дүнгээс үзвэл ноос ноолуур ээрэх үйлдвэрийн үйл ажиллагааны явцад газрын гадаргуу, хөрс, агаар бохирдох зэрэг нөлөөллүүд нь аюулгүй ажиллагааны дүрэм журмыг баримтлаагүйгээс үүсэх нөлөөллүүд байна.

Голлох нөлөөллийг тодорхойлохдоо:

1. Гарч болох бохирдлын түвшинг харгалзан үзэх
2. Сөрөг нөлөөллийн үр дагаврыг бууруулах арга замыг эрж хайхад шаардлагатай мэдээллийг бүрдүүлэх
3. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх арга замын талаар зөвлөмж боловсруулж өгөх явдал юм.

Эдгээр нөлөөллийг бууруулах, үүсэхгүй байх боломжтой бөгөөд төслийн үйл ажиллагааны үед үүсэх гол нөлөөллийг химийн бодисын асгаралт, алдагдалаас үүсэх аюул байна гэж үзлээ. Ингээд энэ нөлөөллийн талаар эрсдлийн үнэлгээний хэсэгт аргачлалын дагуу тусгайлан тооцож үнэлсэн болно.

#### Хүснэгт 7. Төслийн голлох сөрөг нөлөөлөл

Эх үүсвэр	Хөрс	Агаар	Эдэлбэр газар
Химийн түүхий эдийн сав, боодлын хаягдал	Химийн бодисын хаягдал сав, баглаа боодлын хаягдал		
Үйлдвэр болон орчны тоосжилт		Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн битүүмжлэл сайн байх боловч түүхий эдүүдийг зөөх явц болон хүнд машин техникийн засах явцад нарийн ширхэглэг бүхий тоосжилт үүсэх магадлалтай юм.	
Ахуйн хог хаягдал үүсэх	Төслийн дэд бүтэц дээр дурдсан хог хаягдлын судалгаанаас үзвэл өдөрт 6 кг, 1 жилийн хугацаанд 180 кг ахуйн хатуу хог хаягдал гарах болно.		
Төслөөс үзүүлэх дуу чимээ		Үйлдвэрийн дотоод агаар орчинд дуу чимээний тархалт үүснэ.	

### ***Хөрсний элэгдэл, бохирдол***

“Шаргын эзэн” ХХК-ийн ноос ноолуур ээрэх үйлдвэрийн үйл ажиллагаа нь хөрсний элэгдэл, бохирдолд шууд нөлөөлөхгүй боловч үйлдвэрийн орчны газрын хөрс, зам талбайг тохижуулж зүлэгжүүлээгүйгээс хүн, автомашины хөдөлгөөнд өртөн элэгдэлд орох, ил задгай хог хаягдлын цэг байгуулах болон түүнийг ариутгахгүй удах, хогийг зохих график хуваарийн дагуу ачихгүй байх, химийн бодис, материалыг тээвэрлэн зөөх, ачих, буулгах үедээ санамсаргүй алдаж асгах зэрэг шалтгаанаас хөрс бохирдох сөрөг нөлөөлөл гарах магадлалтай байна. Иймээс хүний үйл ажиллагаатай холбогдож гарч болох эдгээр сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, орчны зам талбайг тохижуулж зүлэгжүүлэх, зарим хэсгийг нь хатуу хучилттай болгох, хогийн түр цэгийг шаардлагын дагуу байгуулах, хогийг ойр ойрхон хугацаанд бүрхүүлтэй машинаар зөөж ачуулах, химийн бодисыг зөөх, буулгахдаа шаардагдах техник хэрэгслийг ашиглан маш анхаарал болгоомжтой, ажлын зориулалтын хувцастайгаар ажиллах шаардлагатай юм.

### ***Агаарын химийн бохирдол***

Агаар бохирдуулах үндсэн эх үүсвэрийг байгалийн гаралтай, хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй гэж 2 ерөнхий хэсэгт хувааж үздэг. “Шаргын эзэн” ХХК-ийн үйлдвэрийн үйл ажиллагааны улмаас орчны хөрс эвдэрч тоосжилт нэмэгдэх, химийн бодис тээвэрлэх, ачих, буулгах, зөөх, хадгалах үеийн ууршилтаас гарах хий, хатуу бодисын тоос нь агаарын чанарт нөлөөлөх боловч хөдөлмөр хамгаалалын дүрмийг баримтлан ажилсанаар энэхүү нөлөөлөл маш бага байх болно.

Иймд импортоор авчран борлуулж буй химийн бодисын сав, баглаа боодлын бүрэн бүтэн байдалд байнга хяналт тавих, химийн бодисын алдагдал, ууршилт гарахаас сэргийлэх, ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын зориулалтын хувцсаар хангах, үйлдвэрт агааржуулалтын төхөөрөмж тавих, татах шүүгээ байрлуулах, ажилчдын хувцас солих өрөө гаргаж тохижуулах, ажлын байрны агаар дахь химийн хорт бодисын агууламжийг хянах багаж хэрэгсэлтэй болох зэрэг арга хэмжээг цаашдын төлөвлөгөөндөө тусгаж хэрэгжүүлэх.

Темтар Агаарын чанарын хянагч чийгшил, температур хэмжигч, PM2.5 PM10 агаарын чанарын хэмжигч багажаар үйлдвэр дотор, гадаа агаарын тоосжилтын хэмжээг хэмжсэн.



- Цэвэр орчинд нэг ширхэгийн хэмжээ, ширхэгийн диаметрийн тархалтыг хэмжихэд ихэвчлэн ашигладаг.
- Ажиллуулахад хялбар, тогтвортой ажиллагаатай.
- Эмийн үйлдвэр, электрон үйлдвэрлэл, нарийн машин механизм гэх мэт салбарт өргөн хэрэглэгддэг.
- Гэр доторх болон гадаа амьдрах орчныг тодорхойлоход тохиромжтой.

Зураг 14. Агаарын чанарын хэмжилт хийсэн багаж



Ноос ноолуур ээрэх үйлдвэр дотор явуулсан агаарын чанарын хэмжилт хүлцэх хэмжээнээс бага буюу хэвийн түвшинд байна.

Зураг 15. “Шаргын эзэн” ХХК-ийн ноос ноолуур ээрэх үйлдвэрийн дотор явуулсан агаар чанарын хяналт шинжилгээ



Зураг 16. JHC-240 ULTRASONIC УУРЖУУЛАГЧ АППАРАТ

### ХЭТ АВИАНЫ ҮЙЛДВЭРИЙН ЧИЙГШҮҮЛЭГЧ

#### Хүчин чадал

1. Усны нөөцийн банк – 24л\Ц
2. Агаарын урсгалын хурд – 725м3\Ц
3. Хүчдэл – 220вт\50грц
4. Хүчийн чадал – 2400вт
5. Чийгшүүлэх уур – 110м\*3Рс
6. Хяналтын арга – Микрокомпьютерийн хяналт
7. Гадна хэмжээ – 76мм\*76мм\*64мм
8. Жин – 50кг

#### Тайлбар

- JHC-240 ultrasonic ууржуулагч аппарат нь:

WATER SOURCE \№1 цэвэр усны шугам\наас ус орж FILTER \№2 шүүлтүүр\-ээр дамжин WATER TANK \№3 усны нөөцийн сав\нд хадаглагдаж тухайн савны дээд түвшинд хүрхэд хавлаг хаагддаг.

**УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ  
БАЙРЛАХ “ШАРГЫН ЭЗЭН” ХХК-ИЙН “НООС НООЛУУР ЭЭРЭХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН  
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

WATER TANK \№3 усны нөөцийн сав\ -нд ULTRASONIC \№4 хэт авианы ууржуулагч хавтан\ 3 ширхэг байх ба 110м\*3Pcs чадлаар усыг задлаж 725м<sup>3</sup>/ц хурдаар №5 ПВС хоолойгоор дамжуулж өгдөг.

- Тоон чийгийн хянах самбар дээрээс чийгийг 1%-99% хүртэл тохируулж болно.
- Харицангүйн чийг болон, ууржуулалтын хэмжээнээс хамаарч ихэсгэх багасгах AUTO \авто\, MANUAL \механик\ горимтой.
- Зэвэрдэггүй ган бие бүхий их биетэй.

**Агаарын бохирдол**

Ноос ноолуур ээрэх үйлдвэр төсөл нь “Дакон дор” маркын хатуу түлшний бага оврын зуух ашигладаг. Халаалтын зуухаа ашиглах хугацаа нь 10 сараас 4 сар хүртэл галладаг. 1 сард 7тн сайжруулсан шахмал түлш хэрэглэдэг. 7 сар галлахаар 49тн нүүр хэрэглэнэ.

*Бага оврын усан халаалтын зуух (БОУХЗ)-наас ялгарах хаягдлыг тооцох,  
Бага оврын УХЗ-ны хүчин чадал нь 100кВт хүртэл байх бөгөөд ихэвчлэн хувийн жижиг дэлгүүр,  
цайны газар, зочид буудал зэрэг газруудад халаалтын зориулалтаар ашигладаг.*

Бохирдуулах бодисын хаягдлын хэмжээг дараах томъёогоор тооцно.

$$E = \sum AD \times EF$$

Энд:

E- Бохирдуулах бодисын хаягдлын хэмжээ, кг

AD – Зуух тус бүрээр, түлшний төрлөөр зарцуулалтын хэмжээ, тн/жил

EF – Зуух тус бүрээр, түлшний төрлүүдийн ХК, кг/тн

Хүснэгт 8.” Dakon dor “ бага оврын халаалтын зуухны ХК

Түлшний төрөл	Зуухны технологи	SO <sub>2</sub>	NO <sub>x</sub>	TSP	PM10	PM2.5	CO	NMVOC	NH <sub>3</sub>	Hg
		Нэгж, гр/ГЖ								
Нүүрс/ сайжруулсан шахмал түлш	50 кВт/ц хүртэлх хүчин чадалтай зуух	<b>900</b>	<b>158</b>	<b>261</b>	<b>225</b>	<b>201</b>	<b>4787</b>	<b>174</b>	<b>NE</b>	<b>6</b>
Dakon dor 38 кВт хүчин чаталтай зуух		<b>0,0441</b>	<b>0,0077</b>	<b>0,0127</b>	<b>0,011</b>	<b>0,0098</b>	<b>0,2345</b>	-	-	<b>294</b>

- Төслийн талбайгаас 50 м зайд шууд нөлөөллийн бүс
- Төслийн талбайгаас 100 м зайд шууд бус нөлөөллийн бүсийг авч үзэв.



График 1. PM10 тоосонцрын тархалт

УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ  
БАЙРЛАХ “ШАРГЫН ЭЗЭН” ХХК-ИЙН “НООС НООЛУУР ЭЭРЭХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН  
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тархалтын загвараар бага оврын уурын зуухны эх үүсвэрээс ялгарах агаар бохирдуулагчийн ялгарлын орон зайн тархалтаар тоос /TSP, PM10, PM2.5, хүхэрлэг хийн агууламж, азотын давхар исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл/ гэсэн агаар бохирдуулагч бодисуудаар тооцооллоо.

Салхины хурдыг 4-6 м/с, чиглэл баруун хойноос, 1 гр/сек/м<sup>2</sup> байна гэж үзвэл, 8 метрийн өндөрт хамгийн их тархах тоосжилтийн утга 0.00002 гр/м<sup>3</sup> байх бөгөөд энэ нь эх үүсвэрээс 1 метрийн зайд ажиглагдана. Дээрх загварчлалын бодолтын утга нь 100 метр тутамд гэсэн нөхцөлөөр хийгдсэн бөгөөд эх үүсвэрээс 100 метрийн зайд 0.00002 гр/м<sup>3</sup>, 200 метрийн зайд 0.00001 гр/м<sup>3</sup> байгаа нь MNS 4585:2016 стандартын ЗДХ 500 мкг/м<sup>3</sup> хязгаарын хэмжээнд тархаж байна.

***Нийгмийн эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал***

“Шаргын эзэн” ХХК-ийн ноос ноолуур ээрэх үйлдвэр нь химийн бодисыг тээвэрлэн авчирч хадгалах үеийн ажлын байрын эрүүл ахуйн шаардлагыг хөдөлмөр хамгааллын гол асуудлуудтай холбон авч үзсэн байна. Үүнд ажиллагсдын эрүүл ахуйд хортой хүчин зүйлүүд нөлөөлөхөөс хамгаалах, нөлөөллийг бууруулахад чиглэгдсэн зохион байгуулалтын арга хэмжээ авах техник хэрэгсэл, ариун цэврийн системийг хамруулжээ.

Химийн бодис, материалын үйлдвэрийн доторхи зохиомол бичил уур амьсгалын нөхцөл ба агаар сэлгэлт, чийглэг, тоосжилт, мөн хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийн хангамж, тоног төхөөрөмж, хяналтын багаж хэрэгслийн техникийн бэлэн бус байдал зэрэг нь ажиллагсадын эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлс болох нь манай оронд ажиллаж байгаа ижил төстэй бусад байгууллагуудын үйл ажиллагаа, тэнд явуулсан мэргэжлийн хяналтын байгууллагуудын хэмжилт судалгаанаас харагдаж байгаа билээ. Иймээс үйлдвэрийн байрны гэрэлтүүлэг, температур, чийгшилт, орчны тоосжилт, агаар дахь химийн бодисын агууламж зэрэг бичил орчны үзүүлэлтүүд стандарт нормын хэмжээнээс өөр байх нөхцөлд ажиллагсдын эрүүл мэндэд шууд ба шууд бус байдлаар сөрөг нөлөө үзүүлнэ.



## ГУРАВДУГААР БҮЛЭГ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АВАХ АРГА ХЭМЖЭЭ, ЗӨВЛӨМЖ

“Шаргын эзэн” ХХК-ийн ноос ноолуур ээрэх үйлдвэрийн үйл ажиллагааны явцад гарч болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, химийн бодис, материалыг байгаль орчин, экологид хор хөнөөлгүйгээр хадгалах болон тэдгээрийг хамгийн бага сөрөг нөлөөлөлтэйгээр хадгалах, зөөвөрлөх, устгах, зайлуулах, нөхөн сэргээх замаар тухайн орон нутгийн байгалийн өнгө төрх, хэлбэр, хор аюулгүй нөхцөлд орон нутгийн хүн ам, амьтан ургамал, үржин төлжих нөхцөлийг бүрдүүлэхэд төслийн үйл ажиллагааны гол зорилго оршино. Иймд төслийн болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Энд төслийн үйл ажиллагаанаас нөлөөлөлд өртөж болзошгүй байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрээр нь нөлөөллийг бууруулах арга хэмжээг зөвлөмж болгохын зэрэгцээ техник, технологийн арга хэмжээг санал болгов.

“Шаргын эзэн” ХХК-ийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм-эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл болон эрсдэлийн үнэлгээний үр дүнгээс үзэхэд төслийн үйл ажиллагаанд технологийн болон удирдлага зохион байгуулалтын дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь үүсч болох эрсдэл, сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Эдгээр зөвлөмжийг авч хэрэгжүүлэхдээ энэхүү байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн хууль эрхзүйн бүлэгт орсон хууль, дүрэм журам, стандарт болон Олон улсын конвенцийн холбогдох заалтыг мөрдлөг болгон ажиллах хэрэгтэй.

### 3.1. БАЙГАЛЬ ОРЧНЫ БҮРЭЛДЭХҮҮН ТУС БҮРЭЭР СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ

#### 3.1.1. Агаарын чанар

- ✓ Хог хаягдал шатаахыг хориглож ажиллах
- ✓ Тээврийн хэрэгслийг асаалттай орхихгүй байх
- ✓ Ажлын байранд агааржуулалтыг 1-2 цаг тутам хийж байхаар орчин үеийн дэвшилтэт агааржуулалтын системийг сонгон авах
- ✓ Ажлын байранд таазны сэнс тавих, дотоод агаарыг чийгшүүлэх арга хэмжээ /нойтон цэвэрлэгээ гэх мэт / тогтмол авч хэрэгжүүлэх
- ✓ Ажилтан, ажиллагсад амны хаалт тогтмол хэрэглэж хэвших
- ✓ Ажлын байранд зориулалтын агааржуулагч тавих
- ✓ Үйлдвэрт ашиглаж байгаа нам даралттай зуухыг ашиглахаа больж Атмор ХХК-ийн цахилгаан зуухтай болохыг зөвлөж байна.

#### 3.1.2. Газрын гадарга, хөрсний элэгдэл, эвдрэл

Хөрсний нөөцийг хамгаалах нөлөөллийг бууруулах арга хэмжээ нь ургамал, усны нөөцийг хамгаалах үйл ажиллагаатай нягт уялдаатай юм. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах нь зүйтэй.

- Хатуу хог хаягдлын зориулалтын цэг байгуулах
- Нөлөөлөлд өртөөгүй талбайд мод бут тарьж цэцэрлэгжүүлэх
- Химийн бодис хөрсөнд асгарахаас урьдчилан сэргийлж гадна болон доторх орчныг цементлэх

• Хатуу хучилттай хийгдсэнээс бусад нөлөөлөлд өртсөн сул талбайн хөрсийг сийрүүлэн шимт хөрсөөр 20 см хүртэл зузаантай хучилт хийж ургамалжуулах.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр дээрх зөвлөмжүүдэд тулгуурлан байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний

хөтөлбөр боловсруулагдсан тул төсөл хэрэгжүүлэх хугацаандаа тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дээрх хөтөлбөр төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, БОАЖЯ-аар батлуулан мөрдөж ажиллах шаардлагатай.

### 3.1.3. Унд-ахуйн усны чанартай холбоотой авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд

- Унд ахуйн зориулалттай ус нь халдварт болон нутагшмал өвчин тархах аюулгүй, физик үзүүлэлт, химийн найрлагаараа хор нөлөөгүй, мэдрэгдэх чанараараа харшлахгүй байх нөхцлийг хангасан байх ёстой. Усны чанарын найрлага нь “MNS 900-2005. стандартын шаардлагыг хангасан байх
- Усны тоолууртай болох ашиглалтын гэрээг дүүргийн ЗДТГ болон бусад холбогдох байгууллагатай хийж баталгаажуулах, төлбөрийг цаг тухай бүр төсвийн дансанд оруулах
- Ундны ус хадгалах, нөөцлөх, хэмнэлттэй зарцуулах зорилгоор цэвэр ус нөөцлүүрийн сав ашиглах.
- Ус ашиглалтыг багасгах, бохир уснаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор бага оврын цэвэрлэх байгууламж барих

### 3.1.4. Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Усны нөөц болон чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар дараах зөвлөмжийг өгч байна.

- Газрын доорх усыг бохирдуулагч эх үүсвэр нь хөрсний бохирдол юм. Хөрсөн дээр асгарсан, гоожсон, шатах, тослох материал түүний үе давхаргуудад шүүрэн нэвчиж газрын доорх усыг бохирдуулна. Нөгөө талаар бороо хурын ус чийг, хөрсөнд бий болсон дээрх бохирдлуудыг цааш дамжихад ихээхэн нөлөөлөлтэй байдаг тул нэн түрүүнд хөрсийг шатах, тослох материалаар бохирдохоос хамгаалах, бохирдсон нөхцөлд нэн даруй арга хэмжээ авч байх хэрэгтэй.
- Усны үр ашигтай хэрэглээг эрхэмлэх, бохир усыг бага оврын цэвэрлэх төхөөрөмжөөр цэвэрлэн технологи болон тоосжилт дарах, ногоон байгууламжийн усалгаанд эргүүлэн ашиглах, усны тоолуур суурилуулах, үр ашиггүй зарцуулалтыг багасгах, хяналт тавих
- Ус ашиглах дүгнэлт, гэрээг байгуулан усыг ашиглах,
- Үйлдвэрийн болон ахуйн бохир ус дамжуулах шугам сүлжээний ашиглалтанд байнга хяналт тавьж, гэмтэж, эвдрэх, элэгдэх цоорохоос урьдчилан сэргийлэх
- Хур бороо, үерийн уснаас хамгаалах суваг, далан байгуулах замаар үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсгэж болзошгүй бохирдуулах нөлөөллийг бууруулах
- Өөрийн ашиглалтын талбай дахь болон эргэн тойрны хог хаягдлыг цэвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулж, нутгийн удирдлага, иргэдтэй хамтран ажиллана.
- Үйлдвэрийн технологийн ус хэрэглээний нормыг тогтоож, усыг үр ашигтай зарцуулах, хэрэглээнээс гарсан усыг эргүүлэн ашиглах боломжийг судлаж, хэрэгжүүлэх
- Тоног төхөөрөмжийг угааж цэвэрлэхэд ариутгагч бодис, усыг оновчтой ашиглах;
- Усны хэрэглээг дараах аргаар бууруулах:
- Тоног төхөөрөмжийг угааж цэвэрлэхэд өндөр даралттай, хэмжээ багатай хоолойг ашиглах;
- Автоматаар хаагдах крант хэрэглэх;

### 3.1.5. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

- Хөрс хуулах, ургамлан нөмрөг талхлах газрыг аль болохоор бууруулах арга хэмжээ авч ажиллах
- Үйлдвэрийн эдэлбэрийн ашиглалтгүй хэсгийн сул чөлөөтэй хөрсөн гадаргууг ургамалжуулж ногоон бүс байгуулах

### 3.1.6. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

- Түүхий эд түр цуглуулах талбайд элээ, хэрээ, хээрийн ба оронгийн бор шувуу болон элдэв идэшт шувууд, ялангуяа ялаа, шавж олшрох нь янз бүрийн өвчин эмгэг, халдвар тараах

нөхцөл бүрдэж болзошгүй. Иймд тухайлбал түүхий эд түр буулгах талбай болон хадгалах агуулахад ариун цэвэр, эрүүл ахуй, халдвар судлалын шаардлагад нийцүүлэн ажиллах

- Мөн Элдэв халдварт өвчин тараах хэрээ, жунгаа гэх мэт шувуудыг хэт олноороос урьдчилан сэргийлж ил задгай хог хаягдал, хоол хүнсний үлдэгдэл хаяхгүй байх.
- Төсөл хэрэгжих орчинд хогийн цэг дээр амьтан тэжээл хайж ирэх, орогнох, үүрлэх нөхцөл үүсгэхгүй байх, ахуйн ба үйлдвэрлэлийн хог хаягдлаас амьтан хордох явдлаас сэргийлэх

### 3.1.7. Нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

Төслөөс нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд:

- Аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын дүрмийг баримтлах
- Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт жилд 2 удаа хамруулах
- Техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд байнгын хяналт тавих
- Ажилчдын ажлын байрны аюулгүй орчныг бүрдүүлэх, хүнд хортой нөхцөлд ажиллагсдад нэмэгдэл цалин, урамшуулал олгох мөн хор тайлах бүтээгдэхүүнээр хангах
- Нийт ажилтнуудыг урьдчилсан ба хугацаат үзлэг шинжилгээнд хамруулж мэргэжлийн байгууллагаар ажил мэргэжлийн тохироо хийлгэх
- Хөдөлмөр эрхлэлтийн явцад гарч болзошгүй аюул осол, бэртэл гэмтэл, ердийн болон мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эруул ахуйн менежментийн систем нэвтрүүлэх төлөвлөгөө боловсруулан үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллах
- “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эруул ахуй тухай” хуулийн 31,2-т “Шинээр ажлын байр бий болгох болон ажлын байрны үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл өөрчлөгдөх бүрт, химийн хорт болон аюултай бодис агуулсан түүхий эд, материал ашиглаж үйл ажиллагаа явуулж байгаа бол жилд нэгээс доошгүй удаа ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэнэ” гэсэн заалтын дагуу хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж байх.
- Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан орон тооны ажилтанг томилон, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд ажлын чиг үүргийг тодорхой тусган баталгаажуулах
- Нийт ажилтнуудыг үйлдвэрлэлийн эрсдэлд хүчин зүйлсээс сэргийлэх аюулгүй ажиллах дадал, зан үйлийг эзэмшүүлэх чиглэлийн сургалт, мэдээ мэдээллийг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах ажлыг жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-ийн 15 дугаар зүйлийн 15.1 хэсэгт “Ажил олгогч нь ажилтныг түүний ажлын нөхцөл, ажлын байрны онцлог, чанарын шаардлагад нийцсэн ажлын тусгай хувцас өмд, куртка, комбинезон, малгай, каск, гутал/, хамгаалах хэрэгсэл /маск, хошуувч, нүдний шил, чихэвч, бээлий, доргионоос хамгаалсан бээлий, өндрөөс хамгаалах хэрэгсэл, бэлхэнцэгээр хангаж, тэдгээрийг бүрэн өмсөж хэвшихэд хяналт тавьж ажиллах
- Ажлын талбарт нүд угаах зориулалтын төхөөрөмж, эмнэлгийн анхан шатны тусламжийн цэг бий болгож, анхны тусламжийн хайрцаг, эмийн сан байрлуулж шаардлагатай эм, боолтын материалаар тогтмол хангаж ажиллах

### 3.1.8.Бусад асуудлаар

#### Болзошгүй түймэр, газар ашиглалтын асуудлаар

- Болзошгүй түймрийн үед хэрэглэх гал унтраах хэрэгслийг бэлэн байдалд байлгах, ажилчид түймэр унтраах дадлага туршлагатай болсон байх,

#### Байгаль орчныг хамгаалах, удирдлага зохион байгуулалтын асуудлаар

УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ  
БАЙРЛАХ “ШАРГЫН ЭЗЭН” ХХК-ИЙН “НООС НООЛУУР ЭЭРЭХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН  
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

- Үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийн дүрэм, зааврын дагуу мөрдөн ажиллахыг хөдөлмөр хамгааллын инженер хариуцан ажиллана.
- Юуны өмнө үйлдвэрлэлийн шат дамжлагын дагуу технологийн заавар боловсруулж, түүнийг мөрдөж ажиллана. Барилга Архитектур Корпорацид үндсэн түүхий эд болон материалын дээжээ өгч гарал үүслийн тодорхойлолт, тохирлын гэрчилгээ авч, орц нормыг гаргаж мөрдөнө.
- “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 10<sup>1</sup> дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2 жилд тутамд хийлгэх шаардалагатай гэж үзэж байна.

### 3.1.9. Удирдлага, зохион байгуулалтын талаар

#### 1. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Эрчим хүчний нөөц (цахилгаан, дулаан уур), түүхий эдийг үр ашигтай зарцуулах, бохирдлоос хамгаалах. Үүнд:

- Үйлдвэрлэлийн технологийн зориулалттай уур, ус, эрчим хүчний хэрэглээний нормыг хэрэглэгч мэргэжлийн байгууллагуудтай хамтран боловсруулах, тэдгээрийн хэрэглээг төгөлдөржүүлэх
- Үйлдвэрийн түүхий эдийг удаан хугацаагаар хадгалах үед битүү барилга барьж, агааржуулалтын системийг хийж өгөх
- Хог хаягдлыг тогтсон хугацаанд нь тээвэрлүүлж ачуулж байх
- Бага оврын уурын зуухны янданг 7 хоног тутам хөөлж байх
- Утаа мэдрэгч суурилуулах байнга хянаж байх

#### 2. Ажиллагсдын эрүүл ахуйг хамгаалах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах талаар

- Халуун уур, чийгтэй, чимээ шуугиантай ажилладаг гүйцэтгэн боловсруулах үед гарах чимээ шуугианы хэмжээг багасгах нэмэлт арга хэмжээг авах,
- Үйлдвэрийн газруудын халуун, тоостой, бохир орчинд ажиллагсдад зориулж халуун усны (душ) газартай болох
- Түүхий эдийг ангилан ялгах ажилчдыг хормогч, бээлий, тоосны хошуувч зэргээр хангах
- Ажилчид нүүрсний утаанаас угаартхаас сэргийлэх.

#### 3. Сургалт судалгааны талаар

- Экологид ээлтэй технологийн дэвшлийг үйлдвэрлэлд шуурхай нэвтрүүлэх талаар судалгаа шинжилгээ явуулж байгаль орчин, хүний эрүүл ахуйд халгүй үйлдвэрлэлийн хөтөлбөрийг боловсруулан ажиллах
- Үйлдвэрлэлийн стратегийн болон ойрын зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн технологийн менежмент (сургалт, сурталчилгаа, орчны хяналт)-ийг хөгжүүлэх, удирдлагын байгаль орчны талаарх мэдээллийг сайжруулах
- Байгаль орчин, үйлдвэрлэлийн экологийн талаар сургалтын хөтөлбөр боловсруулж, мэргэжлийн байгууллагатай хамтран нийт ажиллагсдыг сургалтад хамруулах
- Хаягдал, бохирдолд тавих байгаль орчны салбарын олон улсын нормативыг үйлдвэрийн дамжлага дээр мөрдөж ажиллах, орчны хяналт шинжилгээг жилд нэг удаа хийлгэх

### 3.1.10. Үйлдвэрийн үйл ажиллагааны технологийн шинэчлэлт, төгөлдөржүүлэлтийн талаар

- Химийн бодисыг ачих, буулгах, тээвэрлэх, зөөх үед ашиглах орчин үеийн болоод аюулгүй ажиллагааны шаардлагад нийцсэн техник хэрэгсэлтэй болох, гар ажиллагааг механикжуулах.
- Тус компанийн импортоор оруулан ирж борлуулдаг химийн бодис, материал нэг бүр дээр үйлдвэрлэгч компани, үйлдвэрлэлийн арга, бүтээгдэхүүний чанар, шинж чанар, хэрэглээ, аюулгүй ажиллагааны шаардлага, тээвэрлэлт, хадгалалтын нөхцөл болон бусад зүйлсийг хамарсан мэдээллийн сан бүрдүүлэх.

- Цаашдаа орчин үеийн стандартын шаардлагыг хангасан химийн бодис материалын агуулахтай болох, мэргэжлийн байгууллагаар ажлын байрны дүгнэлтийг тогтмол хугацаанд гаргуулж байх.
- Үйлдвэрийн барилгын дотоод тохижилтыг сайжруулах, агааржуулалтын болон галын дохиоллын төхөөрөмжөөр тоноглох, галын болон тэсэрч дэлбэрэх аюултай, онцгой хортой бодисуудыг нэг дор хадгалахгүй байх зэрэг зохион байгуулалтын асуудлуудыг яаралтай шийдвэрлэх нь зүйтэй.

#### ***Агааржуулалтын систем***

Үйлдвэрийн агаарын урсгалын хурд, чийгийн байдлыг зохицуулахын тулд үйлдвэрт агааржуулах системийг суурилуулах зайлшгүй шаардлагатай байна. Химийн бодисоос ялгарч байгаа уур, хий, тоос зэрэг нь ихээхэн хэмжээгээр орчны агаарт тархаж өвчин, хордлого, организмийн гэмтэл, галын ба дэлбэрэх аюулын шалтгаан болох нь их байдаг. Ажлын байранд үүсч байгаа уур, хий, тоосны хортой нөлөөлийг бүх талаар багасгах үндсэн хэрэгсэл бол тоног төхөөрөмжийн шаардлагатай бүх хэсгүүдэд бүрэн бүтэн байдлыг хангах, автоматжуулах, алсын удирдлагатай системээр тоноглох, хортой уур, хий, тоосыг яг үүссэн газраас нь зайлуулж оронд нь цэвэр агаар оруулах замаар хортой нөлөөллийг дотогшоо сорох агаартай холилдон хий, тоосыг зайлуулах орчинд гадагшаа сорох зохих хурд бий болгосноор ажлын бүсэд бий болсон хорт бодисуудыг байранд тархахаас сэргийлнэ. Хэсэгчилсэн гадагшаа сорох агааржуулалтыг ажлын байран дээр бий болсон хортой ба аюултай ялгарлуудыг ажлын байрны агаар луу алдагдах явдлыг зайлшгүй арилгах тохиолдолд хэрэгжүүлнэ. Харин дотогшоо сорох хэсэгчилсэн агаарыг гол төлөв ажилчдыг дулаацуулах, мөн хэт халууцуулах зорилгоор ажиллуулдаг ба агаараар үлээх эдгээр төхөөрөмжийг суурин ба зөөврийн гэж ангилдаг. Агаараар үлээх эдгээр төхөөрөмжөөр агаарын урсгалын чиглэлийг хэвтээ буюу бага зэрэг налуулж үлээлгэх ба энэ нь ажилчны биеийг ажлын байрнаас гарсан хортой бодисын үлээлтийн замд оруулахгүй байхаар төлөвлөж байгаа байдал юм. Мөн ийм аргаар агааржуулалт хийж байгаа үед ажлын байрыг хэт халалтаас болгоомжилж, хэвийн температурыг барих ёстой.

Осол аюулын үеийн агааржуулалтыг ажлын бүсэд гэнэт их хэмжээний хортой бодис (тоосноос гадна) ялгарч болзошгүй тохиолдолд ажиллуулахаар зэхсэн байх ёстой. Осол аюулын үеийн агааржуулалт ямагт гадагшаа сорох зарчмаар ажилладаг тул бохир агаарыг зайлуулна. Осол аюулын үеийн агааржуулалтаар гадагшаа зайлуулсан хортой бодисууд нь хүмүүсийн тогтмол ажлын байр ба бусад газруудад хохирол учруулахааргүй байвал зохино. Осол аюулын үеийн агааржуулалтыг хортой бодисуудын зөвшөөрөгдөх концентрацийн хэмжээнд тохируулсан хийг задлан шинжлэх аппараттай автомат горимоор ажжиллахаар холбоно. Үүнээс гадна ослын үед гарсан хорт бодисуудыг зайлуулах агааржуулалтыг ажиллуулах асуудлыг байран дотроос ч бас гаднаас ч алсын удирдлагаар шийдвэрлэх боломжтой байлгах ёстой.

Гадны агаарыг байранд оруулахын өмнө тусгай агаар цуглуулан цэвэрлэх (шүүх) төхөөрөмжөөр дамжуулна. Тэр нь дотогшоо сорох системд агаартай хамт элдэв хөнгөн хольц атмосферийн тунадас сорогдон орохоос хамгаалсан хөшиг, шүүлттэй байдаг. Дотогшоо оруулах цэвэр агаар хүлээн авах цэг газрын түвшингээс дээш 2-2.5м-ийн өндөрт байх ёстой. Харин дотроос гаргасан бохир агаар, дотогшоо оруулах цэвэр агаартай холилдохоос сэргийлэн цэвэр агаар хүлээн авах, бохир агаар гадагшаа үлээх цэгүүд хоорондоо 10м-ээс доошгүй зайтай байхаас гадна хооронд нь 5-8м-ийн өндөртэй босоо хаалт байрлуулах шаардлагатай. Түүнчлэн цэвэр агаар хүлээн авах цэг ямагт салхины дээд талд байрлахаар дотогшоо ба гадагшаа сорох системүүдийг зохицуулан байрлуулна.

### **Гэрэлтүүлэг**

Ажилтны шинжилгээ хийх, химийн бодис хадгалахаас бусад ажлын байруудыг байгалийн гэрэл нэвтрэх боломжоор хангасан байх ба ажиллагсдын аюулгүй ажиллагаа болон эрүүл ахуйд нийцсэн нэмэлт гэрэлтүүлэг байрлуулсан байх шаардлагатай. Нэмэлт гэрэлтүүлэг тусгайлан шаардагдах ажлын байруудад зохих шаардлагуудыг хангахуйц гэрэлтүүлэг тавина. Гэнэтийн үед буюу ажлын байрны цахилгаан хангамж саатаж гэрэлтүүлэг унтарсан, эвдэрсэн болон нүүлгэн шилжүүлэх шаардлага гарсан үед өөрөө асах автоматчилагдсан гэрэлтүүлгүүдийг ажлын байруудад зохих газруудад байрлуулна.

### **Анхны тусламж**

Төсөл хэрэгжүүлэгч анхны тусламж үзүүлэх мэргэжилтнийг үйл ажиллагааны бүхий л хугацаанд байнгын бэлэн байдалд ажиллуулна. Зохих шаардлагын дагуу бүрэн бүрдүүлсэн анхны тусламжийн хайрцгийг ажлын байрны тохиромжтой газар бүрт байрлуулах ба бүх ажилчид дор хаяж анхны тусламжийн талаархи анхан шатны мэдлэгтэй болсон байх шаардлагатай. Явуулж буй үйл ажиллагааны төрөл, цар хүрэнээс хамаарч тэдгээрт тохирсон анхны тусламжийг үзүүлэхэд тохиромжтой байдлаар тоноглоно. Анхны тусламж үзүүлэх хэсэг болон өрөөнүүдэд бээлий, нөмрөг, амны хаалт зэргийг байрлуулж, цус болон хүний биеийн бусад шингэнээр элдэв халдвар дамжихаас сэргийлнэ.

### **Цахилгаан**

Цахилгааны тоног төхөөрөмжүүдийн тухайлбал, хэлхээ таслагч, хяналтын самбар, кабель, утаснууд, гар багаж зэргийн нөлөөлөлд өртөх ажилчдад ноцтой эрсдэл учруулж болно. Тиймээс доорхи арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

- ✓ Цахилгааны бүх тоног төхөөрөмжүүд, шугамуудад анхааруулсан тэмдэг байрлуулах
- ✓ Цахилгааны бүх утас, кабель болон цахилгаан гар багажнуудын утас ил гарсан, шалбарсан эсэхийг шалгах, зөөврийн гар багажнуудыг ашиглаж болох цахилгаан хүчдэлийн зөвшөөрсөн дээд хэмжээг дагаж мөрдөх
- ✓ Чийгтэй орчинд ажиллах бүх цахилгаан тоног төхөөрөмжид давхар тусгаарлалт, газардуулга хийх зэрэг болно.

### **3.2.2 Хатуу хог хаягдлын түр цэг байгуулах болон зориулалтын хогийн савыг ашиглах зөвлөмж**

Хатуу хог хаягдлыг түр хураан хадгалах зориулалтын сав байрлуулаагүй нөхцөлд орчноор хог хаягдал тархах, салхиар зөөгдөх нөхцөл бүрдэх бөгөөд энэ нь олон талтай сөрөг нөлөөллийн эх үүсвэр болж болзошгүй юм. Иймээс шаардлага хангахуйц хэмжээнд хатуу хаягдлын төрлүүдэд зориулсан түр хураан хадгалах төвлөрсөн цэг байгуулах шаардлагатай байдаг.

Хатуу хог хаягдлын түр цэгийн байршлыг сонгохдоо салхины ноёлох чиглэл, газрын хэвгий, эрүүл ахуйн бүсийн зөвшөөрөгдөх зай хэмжээ зэргийг харгалзан байрлуулах шаардлагатай. Үүнд:

- Хатуу хог хаягдлын төрлүүдэд зориулсан сав байрлуулах
- Технологийн хаягдал
- Хоол, хүнсний хаягдал
- Хуванцар сав, лааз, баглаа боодол
- Бусад

Ангилал бүхий хогийн савны амыг салхинд хогийг тараахгүй байхаар бат бөх зориулалтын битүү тагтай байрлуулах хэрэгтэй. Ил задгай хог хаяхгүй байх талаар анхааруулга санамж бүхий самбар, тэмдэгжүүлэх, хог хаягдлын төрөлд зориулсан хаягжуулалт хийн байршуулах, хуурай хог хаягдалд болгоомжгүй үйлдлээс болон аль нэг шалтгаанаар гал гарах үед ашиглах гал унтраагуур, элс хүрз зэргийг бэлэн байлгах хэрэгтэй.

Хог хаягдал ангилан ялгах, тээвэрлэх арга хэмжээний зөвлөмж: Монгол улсын Хог хаягдлын тухай хууль, Европын холбооны улсын хог хаягдлын олон улсын ангилал зэргийг үндэслэн тус бүтээн

байгуулалтын барилгын ажил болон цаашдын үйл ажиллагаанаас гарах хатуу хог хаядлыг ангилсан байх шаардлагатай бөгөөд эдгээр ангилалын дагуу хог хаягдлыг төрлийн кодоор ангилан ялгаж, тээвэрлэлт хийх хэрэгтэй.

### 3.2.3 Химийн бодисоор бохирдсон хортой, аюултай хог хаягдалыг устгах зөвлөмж

- ✚ Аюултай хог хаягдал үүсгэгчийн код авах
- ✚ Хог хаягдлын тухай хуулийг мөрдөж ажиллах
- ✚ Химийн бодисын сав баглаа боодлыг худалдан авагч нараасаа тоо ширхэгээр нь буцаан татан авч аюултай хог хаягдал устгах тусгай зөвшөөрөлтэй компанид эрх шилжүүлэн хүлээлгэн өгөх
- ✚ Аюултай хог хаягдал цуглуулж түр хадгалах тусгай цэг, хадгалах агуулах бий болгож хаяналттай байлгах
- ✚ Химийн бодисоор бохирдсон материал, эд зүйл, хугацаа дууссан бодис урвалж гэх мэт бохирдсон бүх зүйлийг тусгайлсан хогийн цэгт түр хадгалах
- ✚ Аюултай хог хаягдал авдаг компанитай гэрээ байгуулан ажиллах

## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилготой.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

### Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОХТ/ нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлсэн болно.

Уг БОХТ-г төслийг хэрэгжүүлэгч “Шаргын эзэн” ХХК-аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

Байгаль хамгаалах төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн хураангуй бөгөөд жил бүр хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай буюу байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дүнтэй уялдуулж байх шаардлагатай.

### Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

Химийн бодисыг хадгалах, ашиглах үйл ажиллагаанаас үзүүлж болох болзошгүй болон голлох нөлөөлөлд химийн бодисын хадгалалт, аюулгүйн ажиллагаа болон ажлын байрны эрүүл ахуйн бичил орчны нөлөөлөх байдал нь голлох нөлөөлөлд хамаарахаар байна.

Иймээс төсөл хэрэгжүүлэгч ажиллагсдын ажиллах орчин, хөдөлмөр хамгаалал, химийн бодисын эрсдлийн менежментийн асуудал дээр гол анхаарлаа хандуулж, 2007 оны 04 дугаар сарын 27-ны өдрийн 151/126/52 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”, MNS 4585-98. Агаар орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага, MNS 6458:2014. “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Химийн хорт болон аюултай бодис бүтээгдэхүүний агуулах”, БНБД 21-04-05. Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл, MNS 5566:2005. Аж ахуйн нэгж байгууллагад зайлшгүй байх гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн шаардлага зэрэг стандартуудыг нарийн баримтлан ажиллаж, тухайн бодисын хор аюулгүйн лавлах мэдээлэл (MSDS)-д заагдсаны дагуу химийн бодис бүртэй харьцаж ажиллах шаардлагатай.

БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн жил бүрийн тайланг тухайн оны 12 сарын 1-ний дотор БОАЖЯ-нд ирүүлж, орон нутгийн засаг захиргааны байгууллага, нутгийн оршин суугчдад танилцуулж, тэднээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийн хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тусгасан болно.



УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ  
БАЙРЛАХ “ШАРГЫН ЭЗЭН” ХХК-ИЙН “НООС НООЛУУР ЭЭРЭХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН  
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарах зардал/төг/**

<b>Д/д</b>	<b>Бүрэлдэхүүн хэсгүүд</b>	<b>2024 он</b>
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	2 300,0
2.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө /ногоон байгууламжийн төлөвлөгөө/	720.0
3.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6.	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1300.0
7.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	710.0
8.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	180.0
	<b>Нийт</b>	<b>6290,0</b>

**УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ШАРГЫН ЭЗЭН” ХХК-ИЙН  
“НООС НООЛУУР ЭЭРЭХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

***Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, арга хэмжээний төлөвлөгөө.***

<b>Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд</b>	<b>Урьдчилан сэргийлэх, бууруулах багасгах арга хэмжээ</b>	<b>Арга хэмжээний цар хүрээ</b>	<b>Нийт зардал мян.төгрөг</b>	<b>Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж</b>	<b>Баримтлах хууль журам стандарт</b>
<b><i>1. Агаар орчны асуудлаар</i></b>					
Үйлдвэрийн орчны хөрсний элэгдлээс үүдэлтэй тоосжилт болон химийн бодисын ууршилтын үр дүнд ялгарах хий зэрэг нь агаарын тоосжилт ба бохирдолтыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх эх үүсвэр болно.	Агааржуулалтын систем холбох, шүүлтүүр тавих	Агуулах орчимд	200,0	2024	MNS 0012-013:1991. Ажлын байрын агаар. Ажлын байрны агаарын бүс
	Агуулахын тоосжилт, чимээ шуугиан, чийгшил, гэрэлтүүлэгийн байдлыг сайжруулах		100,0	2024	MNS17.2.3.16-88. ”Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам
	Орчны болон ажлын байрын агаарын бохирдлын байдалд шинжилгээ хийлгэх		ОХШХ-т тусгасан	2024	УСТ3384-82”. Агаар мандлын сорьц авахад тавих ерөнхий шаардлага
Үйлдвэрт ашиглаж байгаа нам даралтын зуухнаас гарах утаа нь агаарын бохирдлын эх үүсвэр болно.	Нам даралтын зуухыг ашиглахаа больж цахилгаан зуухтай болох	Үйлдвэрт 2024 оны хавар	-	2024	Агаарын тухай хууль
<b>Нийт</b>			<b>300,0</b>		
<b><i>2. Дуу чимээ</i></b>					
Ашиглагдаж буй машин, тоног төхөөрөмжөөс үүссэн дуу чимээ орчны шуугианы түвшнийг нэмэгдүүлнэ.	Машин тоног төхөөрөмжийг дуу шуугиан хамгийн бага тарах нөхцөлтэйгээр байршуулан ашиглах	Үйлдвэр дотор	50,0	2024	MNS ISO 226:2003 дуу чимээ – хэвийн норм-түвшний хэмжээ MNS 5002:2000
	Ажиллагсдыг дуу шуугианаас хамгаалах хэрэгслээр хангаж хэрэгжүүлэх	Ажиллагсад	20,0*20 хүн =400.0	улирал тутамд	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
	Дуу шуугианы хэмжилт (1 цэгт дууны түвшин хэмжигч NL-04 багажаар) хийх,	Үйлдвэрийн дотор, гадна	30,0	2024	

**УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ШАРГЫН ЭЗЭН” ХХК-ИЙН  
“НООС НООЛУУР ЭЭРЭХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Нийт			480,0		
<b>3. Хөрсөн бүрхэвчийн асуудлаар</b>					
Химийн бодисын санамсаргүй алдагдал, ахуйн хог хаягдлыг зориулалтын цэгт төвлөрүүлж графикт хугацаанд ачиж зайлуулахгүй байх зэрэг нь хөрснийг бохирдуулна.	-Бодисыг их хэмжээгээр асгарахаас болгоомжилж үргэлжийн хянуур ажиллах -Асгарсан тохиолдолд MSDS-Д заасны дагуу яаралтай арга хэмжээ авах -Хүнсний сод, элс, шороо, вермикулитыг бэлэн байлгах	Агуулах орчимд	100,0	2024	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Химийн бодис тээвэрлэх ачиж буулгах Хөрс элэгдэж эвдрэл орно Мөн хүн, машины хөдөлгөөний улмаас агуулахын орчмын хөрс элэгдэлд орно.	Өөрийн эзэмшлийн талбайгаас төв гол зам хүртэлх замыг хайрган хучилтай болон хатуу хучилттай болгох	Төслийн орчимд	ҮАЗ	ҮАХүрээнд	
Нийт			<b>100,0</b>		
<b>4.Газрын доорх усны асуудал</b>					
Гүний ус бохирдох Шатах тосох материал хөрсөнд нэвчиж гүний усанд нөлөөлөх	Худгийг хашаалж эргэн тойрныг нь цементлэх	Худгийн ойр	500,0	2024	-Байгаль орчныг хамгаалах тухай хууль, - Усны тухай хууль
Төслийн явцад усыг их хэмжээгээр, замбараагүй хэрэглэсэн тохиолдолд усны нөөцөд шууд нөлөөлөх магадлалтай	Усны нөөц хомсдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, Тоолуурын заалтын дагуу ус ашигласаны төлбөрийг төлөх	Төслийн хүрээнд	-	Үйл ажиллагаа эрхлэхдээ сар бүр	
Нийт			<b>500,0</b>		
<b>5.Удирдлага зохион байгуулалтын талаар</b>					

**УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ШАРГЫН ЭЗЭН” ХХК-ИЙН  
“НООС НООЛУУР ЭЭРЭХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Энэхүү тайлангийн сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлэх	Үйлдвэрийн ажилчидад	-		Компаний дотоод журмаар
Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх дохиоллын систем суурилуулах		100,0	2024	
Ажиллагсадыг жилд 1 удаа галын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт явуулах		250,0	2024	
Химийн бодистой ажиллах аюулгүй ажиллагааны сургалт тогтмол зохиож байх		250,0	2024	
Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах,		40 * 20 хүн =80,0	2024	
Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээ бүрэн хангах		240,0	1 удаа	
Ажлын байранд аюулгүйн шүршүүр болон нүд угаах зориулалтын угаалтууртай болгох		ҮАЗ	2024	
<b>Нийт дүн</b>			<b>2000,0</b>	

**Ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө /ургамлан нөмрөг хамгаалах/**

“Ноос ноолуур ээрэх үйлдвэрийн” төслийн онцлогоос хамааран ногоон байгууламжийн төлөвлөгөөг боловсруулахдаа Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолын хавсралт “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ ажлын хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийг үйлдвэрийн орчны ногоон байгууламжыг нэмэгдүүлэх, цэцэрлэгжүүлэлтийг сайжруулах үүднээс мод тарих ажлыг оруулсан. Ногоон байгууламж байгуулах зөвлөмжийг төслийн БОННУ-д тодорхой тусгаж зардлын тооцоог гаргасан ба энэхүү зардлыг төслийн бүтээн байгуулалтын төсөвт суулгаж өгөх нь зүйтэй.

**Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө /ургамлан нөмрөг хамгаалах/**

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
<b>Үйлдвэрийн орчинд, ногоон байгууламж бий болгох</b>	Төв аймгийн Батсүмбэр суманд байрлах /координат: х- 629832.338, у-5350330.98/ 000734305 улсын бүртгэлийн гэрчилгээний дугаартай 2000 м.кв талбайтай газарт 100ш хайлаас, шинэс тарих.	Нийт талбайн захаар 30ш	100ш х 6000₮ = <b>600 000.0 ₮</b>	Төсөл хэрэгжих хугацаанд	Байгаль орчин, эвдэрсэн газрын техникийн нөхөн сэргээлт. MNS5914:2008; Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хамгаалалт. MNS5916:2008; Эвдэрсэн газрыг

**УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ШАРГЫН ЭЗЭН” ХХК-ИЙН  
“НООС НООЛУУР ЭЭРЭХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

<b>Ногоон байгууламжинд арчилгаа тордолгоо хийх</b>	Ногоон байгууламжийн усалгаа, хэлбэржүүлэлт хийх тайралт,	Төсөл хэрэгжих орчинд	120.0	Төсөл хэрэгжих хугацаанд	ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага. MNS5918:2008;
<b>Нийт</b>			720,0		

**Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө**

Ангилал	Эх үүсвэрээс гарах хог хаягдлын төрөл	Код	Аюулын зэрэглэл	Жилд гарах нийт хэмжээ,	Дахин боловсруулах	Устгах	Хадгалах	Ландфилл хийх	Зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагад нийлүүлэх	Баримтлах стандарт, аргачлал
Ахуйн	Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх			<b>4.2 тн</b>	+	үгүй	<b>Зориулалтын саванд хадгалах</b>		СБД ТҮК 30,0*12=360.0	Хог хаягдлын тухай хууль
	Ангилан ялгаж тус тусад нь хийх савтай болгох				+	үгүй	<b>Ангилан ялгаж</b>		50,0	
Аюултай	Хортой бодисын үлдэгдэл	5 0109*	X	Үүсэх хэмжээг тодорхойлох боломжгүй	+	-	+	-	<b>300,0</b>	
	Хагуу Шингээгч болон шүүлтүүрийн материал,	5 02 01*	X		-	-	+	-	+	
<b>НИЙТ</b>									<b>710,0</b>	

Тайлбар

“X”- хяналттай хог хаягдлыг тэмдэглэгээгээр

“X” гэсэн тэмдэглэгээтэй хог хаягдлыг аюултай хог хаягдалд хамруулах эсэхийг шинжилгээгээр тогтоох ба аюултай шинж чанар үзүүлэгч бүрэлдэхүүнийг босго түвшинтэй тэнцүү болон түүнээс дээш хэмжээгээр агуулж байвал “аюултай” гэж үзнэ.

**УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ШАРГЫН ЭЗЭН” ХХК-ИЙН  
“НООС НООЛУУР ЭЭРЭХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө**

<b>Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө</b>	<b>Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ</b>	<b>Нэгжийн өртөг (мян.төг)</b>	<b>Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж</b>	<b>Баримтлах стандарт, аргачлал</b>
Байгалийн давагдашгүй хүчин зүйл болж гал гарч химийн бодис галд өртөж шатвал аюултай нөхцөл байдал үүснэ.	Байгаль хамгаалал, болзошгүй түймрээс урьдчилан сэргийлэх талаар ухуулга, сурталчилгааныг самбар хийж байрлуулан, тухай бүрд нь шинэчилж байх	200.0	2024	Галын аюулгүй байдлын тухай хууль
	Галын багаж хэрэгсэл авч ашиглахад бэлэн байдлаар байрлуулах (амьсгалын нэг бүрийн хамгаалалтын аппарат, галын хор, гал унтраагч, усан шүршүүр, гал унтраах хуурай хэрэгсэл, хөөс, нүүрсхүчлийн хий гэх мэт)	200.0	2024	MNS8 5566:2005. Аж ахуйн нэгж байгууллагад зайлшгүй байх гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн шаардлага
	Бодис урвалжуудын хор аюулын зэргийг харуулсан тэмдэг, тэмдэглэгээг монгол тайлбараар дэлгэрэнгүй хийх	100.0	2024	MNS5029:2011. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах
Химийн бодис их хэмжээгээр асгарвал аюултай нөхцөл байдал үүснэ.	Ослын үед ашиглах гар болон автомат ажиллагаатай дуут дохиололтой болох	250.0	2024	MNS 6458:2014. “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Химийн хорт болон аюултай бодис бүтээгдэхүүний агуулах”
	Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хоосон сав, бортого, бортого онгойлгогч, наалддаг шошго, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэрэг багаж хэрэгсэлийг бэлэн байлгах	350,0		
	Болзошгүй тохиолдлоор химийн бодис асгарсан тохиолдолд хэрэглэх зориулалтын шингээгч, хүнсний сод, хуурай элс, шороо, тогтворжуулагч, үртэс гэх мэт материалуудыг ажлын талбарт бэлэн байлгах	200.0	2024	Тухайн бодисын хор аюулгүйн лавлах мэдээлэл (M808)
<b>Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний нийт зардал</b>		<b>1300,0</b>		

**БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь**

УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ШАРГЫН ЭЗЭН” ХХК-ИЙН  
“НООС НООЛУУР ЭЭРЭХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Нийслэлийн БОГазарт	Уулзалт, санал асуулга	БОМТ болон Хяналт, шинжилгээний биелэлтийг тайлагнах	11-р сар	Нийслэлийн БОГ-ын дүгнэлт	Сүхбаатар дүүргийн 20-р хороо
БОАЖЯ-ны ХБОБНУГ-т	-	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	12-р сар	-	-

**Төсөл хэрэгжүүлэх тухайн жилийн төлөвлөгөөний зардалд 4 490.0 мян.төг төлөвлөсөн.**

## ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг **“орчны хяналт шинжилгээний хөтөлбөр”** гэнэ.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тухайн төслөөс байгаль орчины бүрэлдэхүүн хэсэг /ус, хөрс, ургамал гэх мэт/ тус бүрт гарах бохирдол, аливаа өөрчлөлтийг хянах шинжилгээний арга аргачлал, хяналт шинжилгээ хийх хугацаа, сорьц авах болох хэмжилт хийх цэгийн байршил, баримтлах стандартууд зэргийг тодорхойлно.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, байгаль хамгаалах төлөвлөгөөг улам боловсронгуй болгох, байгаль орчноо хамгаалах, орон нутгийн захиргаа, хяналтын болон нутгийн оршин суугчдад бодитой мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой. ОХШХ нь БОХТ-тэйгээ нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай.

Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин, ногоон хөгжлийн яам/-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “Шаргын эзэн” ХХК хариуцах болно.



№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төгрөг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
<b>1. Агаарын чанар</b>					
1.1	Агаарын бохирдлын (NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> , CO, Тоос) шинжилгээ хийлгэж байх	Үйлдвэрийн гадна ба дотоод орчинд	Агаарын найрлага: жил бүрийн 4 сард	Багажийн түрээсийн зардал: 1 багаж 40.0 х жилд 1 удаа* 5 жил <b>НИЙТ 200,0</b>	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга
1.2	Дуу шуугиан, чичиргээ: химийн ууршигтай ба идэмхий хорт бодисууд		Жилд бүрийн 4 сард	Багажийн түрээсийн зардал: 1 багаж 30.0 х жилд 1 удаа* 5 жил <b>НИЙТ 150,0</b>	MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшиний хэмжээ
<b>2. Хөрсний бохирдол</b>					
2.1	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO <sub>3</sub> , P <sub>2</sub> O <sub>5</sub> , K <sub>2</sub> O), хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд, кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр	Төслийн талбайд 2 цэг сонгох /	3,8 сард	2 цэгт х 2 дээж х жилд 1 удаа х 5 жил /15.0+25.0/ <b>НИЙТ 400.0</b> /Хөрсний химийн шинжилгээ 1 дээж -15.0 төг, хүнд металлын шинжилгээ 1 дээж- 25.0 төг/	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2016 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
<b>3. Газрын доорх ус</b>					
3.1	Эрүүл ахуйн	Гүний худгаас	8 сард	1 удаа 160.0	

УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ШАРГЫН ЭЗЭН” ХХК-ИЙН “НООС  
НООЛУУР ЭЭРЭХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа давтамж	ба	Шаардагдах зардал (мян.төгрөг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын 5 жилийн нийт зардлын дүн				910.0	

Төсөл хэрэгжүүлэх тухайн жилийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нийт зардалд 180,0 мян.төг төлөвлөж өгсөн